

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
3 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2017.03.20

Газрын удирдлагын хэлтэс:

Аймгийн Засаг даргын 5 захирамж шинээр гарсан. Үүнд:

- Газар эзэмших эрх шилжүүлэх тухай – 3
- Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх тухай-1

Мөн Сүмбэр сумын газрын даамал 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд батлагдсаны дагуу Тэрэгтэд 1008, өөхийд 400 иргэний материалыг 1 сард хүлээн аваад байна.

Газар өмчилж аваагүй тодорхойлолтыг 10 иргэнд гаргаж өгөв.

Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явагдан аймгийн Засаг даргаас томилогдсон комисс 2 байршилд 4 төсөл ирүүлснээс "Мон суль" ХХК, "Есөнгөл-Эрдэнэ" ХХК-ийн ирүүлсэн төслүүд шалгарсан болно. Шалгарсан компаниудтай гэрээ байгуулан, одоогоор шийдвэр гаргах шатандаа явж байна.

2014-2016 онуудад аймгийн хэмжээнд гэр бүлийн хэрэгцээнд үнэ төлбөргүй шинээр газар өмчилсөн болон гэр бүлийн дундын өмчлөлөөс хасагдсан иргэдийн мэдээллийг ГЗБГЗЗГ-т цахимаар хүргүүлэв.

Газрын төлбөр, татварын талаар:

2017 оны 3 дугаар сарын 20-ний өдрийн байдлаар өссөн дүнгээр газрын төлбөрийн орлого 22762,2 мянган төгрөг байна.

Геодези, кадастрын чиглэлээр:

- Сүмбэр сумын 1, 2, 3-р багийн нутаг дэвсгэрийг харуулсан байр зүйн зургийг албан хэрэгцээнд зориулан аймгийн Цэргийн штабд,
- Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын кадастрын зургийг Зиргэнд,
- 1 иргэний газарт хэмжилт хийж кадастрын зургийг тус тус гаргаж өгөв.

Барилга, хот байгуулалтын чиглэлээр:

Барилга, хот байгуулалтын яамнаас зохион байгуулсан “Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай”хуулийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам сэдэвт хэлэлцүүлэгт 2017.03.15-ны өдөр “Бадрах-70”СӨХ-ны захирал Д.Доржпүрэв, БХБХэлтсийн дарга Б.Даваажаргал нар оролцлоо.

Аймгийн Засаг даргатайбайгуулсан 2017 оныүр дүнгийн гэрээнд тусгагдсан дараах ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- 1-д заасны дагуу барилгын материалын сорил шинжилгээний лабораторын барилгын асуудлыг шийдвэрлэхээр барилгын зураг төслийг боловсруулах ажил хийгдэж байна.
- 4-д заасан заалтын дагуу 2017.03.16-ны өдрийн А/78 дугаар Засаг даргын захирамжаар Сүмбэр сумын 3-р багийн нийтийн эзэмшлийн орон сууцны барилгуудын дээвэр, дээврийн адрын хөндий, агааржуулалт, хана, суурь,

техникийн давхар, үндсэн бүтээцийн элэгдэл, эвдрэл гэмтэлд үзлэг шалгалт хийх ажлын хэсэг байгуулагдаад байна.

Мөн нийтийн эзэмшлийн орон сууцны барилгын орцны саравчинд хүчитгэл хийх ажлын төсөвт өртгийг тооцоолон, төсвийн тодотголд оруулахаар саналыг боловсруулаад байна.

- 12-д заасны дагуу Үндэсний хөтөлбөрүүдийн тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилллаж байна.
- 27-д заасны дагуу “Шивээ-Овоо”ХК-ийнажилчдын цайны газрын барилгын архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулан, баталгаажуулсан байна.
- 33-д заасны дагуу “Төрийн банк”-тай хамран “Ус-Ду”ОНӨААТҮГазар, СӨХ, ЦТСүлжээний газар, Аймгийн холбооны газрууд айл өрхийн ус дулаан, хог хаягдал, СӨХ, цахилгааны төлбөрийн хураан авалтын үйл ажиллагааг нэгдсэн системд оруулах ажлыг зохион байгуулж айл өрхийн нэрийн тулгалт хийж, нэгдсэн мэдээллийг банкинд гарган өгөх ажил хийгдэж байна.
- Мөн орон сууцны эрэлт хэрэгцээг тодорхойлох зорилгоор саналыг боловсруулан иргэдээс судалгааг авч ажиллаж байна.

Захиалагчийн хяналт:

• Баянтал сумын ЗДТГазртай 2017 оны хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналтын гэрээг байгуулсан гэрээний дагуу Баянтал сумын 4 дүгээр сургуулийн дотуур байрны барилгын доторх засварын ажилдзахиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Ажлын гүйцэтгэгчээр “Харвайн толгой” ХХК ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл- 65%

